



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 184,370,000.00 (нэг зуун наян дөрвөн сая гурван зуун далан мянган) төгрөгийн балансын үнэ, 95,257,833.22 (ерэн таван сая хоёр зуун тавин долоон мянга найман зуун гучин гурван төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан суудлын автомашиныг Барилгын политехник коллежид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Барилгын политехник коллежийн захирал Г.Нямдулам нарт дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн  
 330 дугаар тогтоолын хавсралт

"ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ"-НААС БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИД БАЛАНСААС  
 БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

| Д/д             | Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар                | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Нийт гүйлт (км) | Балансын үнэ   | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)   | Үлдэх өртөг  |
|-----------------|--|-----------------------------------|-----------------|--|--|--|
| 1               | Ланд 200, 1078- УБҮ, JTMDV09J5B4055411 Суудлын автомашин | 2010/2011                         | 129,402         | 184,370,000.00   | 95,257,833.22  | 89,112,166.78  |
| <b>НИЙТ ДҮН</b> |  |                                   |                 |  |  |  |
|                 |  |                                   |                 | <b>184,370,000.00</b>                                      | <b>95,257,833.22</b>   | <b>89,112,166.78</b>   |
|                 |  |                                   |                 | (нэг зуун наян дөрвөн сая гурван зуун далан мянган төгрөг) | (ерин таван сая хоёр зуун тавин долоон мянга найман зуун гучин гурван төгрөг хорин хоёр мөнгө) | (наян есөн сая нэг зуун арван хоёр мянга нэг зуун жаран зургаан төгрөг далан найман мөнгө) |